



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/601

Булган сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дугаар зүйлийн 66.1, “Эрүүл мэндийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн 11.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139, 2023 оны А/256 дугаар тушаал, Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны А/273, А/314 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийн 1.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоо”-г орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг), үзлэгийг чанарын өндөр түвшинд, үр дүнтэй зохион байгуулахыг Нэгдсэн эмнэлэг (М.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.


3. Харьяаллын хүн амыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд бүрэн хамруулах, даатгалгүй иргэдийг даатгалд хамруулж, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог эрчимжүүлэх ажлын зохион байгуулалт, хамрагдалтын явцад хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Батчимэг)-д даалгасугай.

5. Энэхүү захирамж батлагдсантай холбоотойгоор 2022 оны А/278 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
08 дугаар сарын 23-ны өдрийн А/601 дугаар  
захирамжийн хавсралт

**ХҮН АМЫН НАС, ХҮЙС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛД СУУРИЛСАН ЗОНХИЛОН  
ТОХИОЛДОХ ХАЛДВАРТ БОЛОН ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ, ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ, ОНОШИЛГОО-Г ЗОХИОН  
БАЙГУУЛАХ АЙМГИЙН АЖЛЫН ХЭСГИЙН ШИНЭЧИЛСЭН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)  
Ж.Ганболд (Боловсрол шинжлэх ухааны газрын  
дарга)  
Ц.Энх-Амгалан (Нийгмийн даатгалын хэлтсийн  
дарга)  
Б.Ариунболд (Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн  
дарга)  
М.Бямбасүрэн (НЭ-ийн даргын үүргийг түр орлон  
гүйцэтгэгч)

Сумдын Засаг дарга нар  
Өрх, сумдын Эрүүл мэндийн төвүүдийн дарга нар

Нарийн бичгийн дарга: М.Солонго (Аймгийн Засаг даргын тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)